

**1.ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ҮЙЛДВЭР ЭРХЛЭГЧИД, ХОЛБООДТОЙ ХИЙСЭН ОЛОН
НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛ**

№	Хуулийн төслийн холбогдох заалт	Байгууллага, хувь хүн	Ирүүлсэн санал				Тусгасан эсэх (Тайлбар, үндэслэл)
			Нэмэх	Хасах	Өөрчлөх	Найруулах	
1	Хүнд үйлдвэрийн тухай хууль тогтоомж хэсэгт Татварын ерөнхий хуулийг нэмж оруулах	Металл боловсруулалт инженерчлэлийн холбоо	+				Хуулийн төслийн 2 дугаар зүйлд Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ. гэж заасан тул нэрээр дурдагдаагүй ч холбогдох хуулиуд тусгагдсан гэж ойлгож болно.
2	5.1-ийг дараах нэршлээр оруулах. 5.1.1. Хар болон өнгөт металл боловсруулах үйлдвэрлэл 5.1.2. Машин үйлдвэрлэл болон металл боловсруулах үйлдвэрлэл 5.1.3. Хими болон газрын тосны бүтээгдэхүүн үйлдвэрлэл 5.1.4. Барилгын материалын үйлдвэрлэл 5.1.5.Цахилгаан ба электрон техникийн үйлдвэрлэл 5.1.6. Зураг, төсөл, зохион бүтээх, зөвлөх, баталгаажуулах оюуны үйлдвэрлэл	Металл боловсруулалт инженерчлэлийн холбоо			+	+	Саналыг хүлээн авсан. 5.1.4 нь Барилгын яаманд хамрах бөгөөд “төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл” гэсэн нэршлээр УУХҮ-ийн сайдын эрхлэх асуудалд хамаарах үйлдвэрлэлийг тусгасан. 5.1.6 нь хүнд үйлдвэрийн салбарт хамаарахгүй бүтээлч үйлдвэрлэлд хамаарах учир хуулийн төсөлд тусгаагүй.

3	Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх зорилго хэсэгт “дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэхийг дэмжих” гэх	Металл боловсруулалт инженерчлэлийн холбоо				+	Найруулгыг хүлээн авсан.
4	Хүнд үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний үндсэн төрлүүд, үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импортын хэмжээ, тайланг жилд нэг удаа зайлшгүй мэдээллийн санд оруулах гэж тусгах	Металл боловсруулалт инженерчлэлийн холбоо				+	Хуулийн төслийн 11.2.3.хүнд үйлдвэрлэлийн салбарын бүтээгдэхүүний үндсэн төрлүүд, үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импортын хэмжээ; 11.3.Мэдээллийн сантай холбоотой харилцааг энэ хуулийн 15.1.9-д заасан журмаар зохицуулна. Гэж тусгасан.
5	Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн эксперттэй болоход санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг тусгах	Металл боловсруулалт инженерчлэлийн холбоо	+				Хуулийн төслийн 10 дугаар зүйлийн 10.3-т Хүнд үйлдвэрийн чиглэлээр судалгаа, хөгжлийн ажил эрхлэх иргэн, хуулийн этгээдэд судалгаа, хөгжлийн зардлын дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батална гэж тусгасан.
6	Хүнд үйлдвэрлэлийн салбарын үйлдвэрүүдэд ажиллаж байгаа ИТА нарын 30-иас доошгүй, ажиллагсдын 50-иас доошгүй хувийг Монгол улсын иргэн байхаар зохицуулах	Металл боловсруулалт инженерчлэлийн холбоо	+				Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн дагуу Аж ахуйн нэгж байгууллагад гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт монгол ажиллагчдын тодорхой хувь хүртэл

							тухайн үед нь Засгийн газраас тогтоодог учир энэ заалтыг оруулах шаардлагагүй гэж үзсэн.
7	Үүсмэл ордын тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулж буй катодын зэсийн үйлдвэр нь боловсруулах чиглэлийн үйлдвэр бөгөөд хүнд үйлдвэрийн хуулийн төслийн дагуу давхар зөвшөөрөл нөхцөл үүсэхээр байгааг анхаарч Ашигт малтмалын тухай хуультай уялдуулах	“Ачит Ихт” ХХК			+		Үүсмэл ордын ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхар тусгай зөвшөөрөл авах шаардлагагүй. Энэ нь хуулийн үйлчлэх хүрээнд хамаарахгүй.
8	5.1-д заасан үйлдвэрлэлийн ангилалд өнгөт металлын боловсруулах үйлдвэрийг тодорхой зааж оруулах	“Ачит Ихт” ХХК	+				5.1.1.хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл; гэж тусгасан.
9	Зарчим хэсэгт тусгасан байгаль орчинд ээлтэй гэдгийг байгаль орчинд сөрөг нөлөө багатай гэж найруулах	“Ачит Ихт” ХХК				+	6.2.3.байгаль орчинд сөрөг нөлөөгүй байх; гэж тусгагдсан.
10	Хувийн хэвшлийн хүнд үйлдвэрийн зохицуулалтыг нэмэх	“Ачит Ихт” ХХК	+				Хуулийн төсөл нь төрийн өмчит болон хувийн хэвшлийн аль ч үйлдвэрт үйлчилнэ.
11	Төрийн оролцооноос гадна төр хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд төр ямар	“Ачит Ихт” ХХК				+	Хуулийн төслийн 18 дугаар зүйлд тодорхой заасан.

	үүрэгтэй болохыг тодруулах						
12	Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас үзүүлэх дэмжлэгийг бодитой болгох	“Ачит Ихт” ХХК	+				Хуулийн төслийн 9, 10, 11, 15, 16 дугаар зүйлд Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас үзүүлэх дэмжлэгийг тодорхой заасан.
13	Хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон хуулийн төсөлд туссан бусад журмуудыг бүрэн шийдвэрлэх	“Ачит Ихт” ХХК				+	Хуулийн төслийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулсан бөгөөд хуулийн төсөлд орсон журмуудыг хууль батлагдсаны дараа боловсруулж, батлуулан хэрэгжүүлэх болно.
14	Үйлдвэрийг хөгжүүлэх зорилтыг үндэсний бодлогын түвшинд тодорхойлох	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК				+	Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх зорилго нь эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг ахиулах, импортыг орлох, экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх замаар үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад оршино. гэж тодорхойлсон.
15	Хүнд үйлдвэр эрхлэгчийн хууль ёсны эрх ашиг, сонирхлыг хамгаалах, дэмжих арга хэмжээ авах	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК	+				Хуулийн төслийн 9, 10, 11, 15, 16 дугаар зүйлд Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас үзүүлэх дэмжлэгийг тодорхой

							заасан. Түүнчлэн 14.1.3 дахь заалтад хамгаалалтын зохицуулалтыг тусгаж өгсөн.
16	Хүнд үйлдвэрийн салбарын үйлдвэрийн ангиллыг эргэн харж, өргөжүүлэн томьёолох	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК				+	5.1.Хүнд үйлдвэрт дараах үйлдвэрлэлийн салбарыг хамруулна: 5.1.1.хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл; 5.1.2.машин үйлдвэрлэл; 5.1.3.металл боловсруулах үйлдвэрлэл; 5.1.4.нүүрс боловсруулах үйлдвэрлэл; 5.1.5.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл; 5.1.6.химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл; 5.1.7.төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл; 5.1.8.төмөрлөгийн хог хаягдлыг боловсруулах үйлдвэрлэл. 5.2.Энэ хуулийн 5.1-д заасан үйлдвэрлэлийн салбарт хамаарах ангиллын жагсаалтыг Засгийн газар батална.гэж тодорхой тусгасан.
17	Хүнд үйлдвэрт тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл олгох журмыг тодорхой болгох	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК				+	Хуулийн төслийн 7 дугаар зүйлд тодорхой заасан.

18	Хүнд үйлдвэрийг дэмжих хэмжээнд дэд бүтцийн бүтээн байгуулалтыг төрөөс хариуцах, хүнд үйлдвэрт шаардлагатай түүхий эд, тоног төхөөрөмжийг импортлоход гааль, НӨАТ-өөс чөлөөлөх, ААНОАТ-аас чөлөөлөх,	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК	+				Дагалдах хуулийн төсөлд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуулийн төслийн 5.1-д заасан үйлдвэр барихад импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувь хэмжээгээр ногдуулах боломжтой байхаар тусгасан. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна” гэж заасны дагуу үйлдвэр барих зориулалтаар импортлох тоног төхөөрөмжийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах асуудлыг Сангийн яамтай тохиролцож 2023 оны төсөвт тусгах боломж бүрдэнэ.
----	--	--------------------------------	---	--	--	--	--

19	Боловсон хүчнийг бэлтгэхэд төрөөс дэмжих	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК				+	Хуулийн төслийн 12 дугаар зүйлд Хүний нөөцийн хөгжлийн дэмжлэгийг тодорхой заасан.
20	Дотоодын бүтээн байгуулалтыг Хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжид худалдан авах	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК				+	Хуулийн төслийн 14.1.3, 14.1.4 дэх заалтад тодорхой тусгасан.
21	Хүнд үйлдвэрийг дэмжих сан байгуулах	Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХК				+	Цар тахлын улмаас эдийн засгийн нөхцөл байдал хүндэрсэн, тухайн жилийн улсын төсөвт сангийн хөрөнгө тусгагдаагүй, Улсын төсөвт дарамт учруулахаар байгаа тул боломжгүй гэж үзсэн. Өмнө байсан энэ төрлийн санг 2019 онд хуулийг нь хүчингүй болгох замаар татан буулгасан.
22	ҮТП-ийн үйл ажиллагааг газрын төлбөр г.м татвар, хураамжаас чөлөөлсөн байдаг. Харин шинээр үйлдвэр байгуулах гэж буй ААН-ийн гадаадаас импортоор оруулж ирж буй тоног төхөөрөмж, техник хэрэгсэл дээр гаалийн албан татвар маш өндрөөр тавигдаж байгаа нь ҮТП-ийн хөгжилд саад болж байна гэж үзэж байна. Тиймээс	“Налайхын үйлдвэрлэл, технологийн парк” ОНӨААТҮГ, Мэргэжилтэн Батбилэг	+				Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна.гэж заасан тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн асуудлыг тусгах боломжгүй болно. Харин Хөрөнгө оруулалтын

	эдгээр ААН-ийн үйл ажиллагааг дэмжих үүднээс энэхүү татваруудыг тодорхой хугацаагаар чөлөөлөх саналтай байна.						тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг "0" хүртэлх хувь, хэмжээгээр ногдуулж болохоор тусгасан.
23	Хуулийн төсөлд санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэж оруулсныг хөрөнгө оруулалтыг татах, урт хугацаатай бага хүүтэй зээлээр дэмжих гэж томъёолох	“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан	+				Хуулийн төслийн 13.1.2-т хөнгөлөлттэй зээл олгох болон зээлийн баталгаа гаргах дэмжлэгийг тодорхой болгосон.
24	Үйлдвэрт борлуулалтыг хамгаалах, дэмжих чиглэлээр тодорхой заалт оруулах	“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан				+	Хуулийн төслийн 14.1.3.хүнд үйлдвэрийн бүтээгдэхүүний дотоодын зах зээлийг хамгаалах эрх зүйн зохицуулалтыг бий болгохоор заасан.
25	Татварын таатай нөхцөл, уян хатан эрх зүйн зохицуулалт оруулах	“Үндэсний аж үйлдвэрийн зөвлөл” ТББ-ын гүйцэтгэх захирал Д.Жаргалсайхан	+				Дагалдах хуулийн төсөлд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлд хуулийн төслийн 5.1-д заасан үйлдвэр барихад импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувь

							хэмжээгээр ногдуулах боломжтой байхаар тусгасан. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна” гэж заасны дагуу үйлдвэр барих зориулалтаар импортлох тоног төхөөрөмжийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах асуудлыг Сангийн яамтай тохиролцож 2022 оны төсөвт тусгах боломж бүрдэнэ.
26	Боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах талаар заалт оруулах	Иргэн Лхагвасүрэн	+				Хуулийн төслийн 14.1.5.Монгол Улсад олборлосон, баяжуулсан, хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг боловсруулах үйлдвэрт тэргүүн ээлжинд, зах зээлийн үнээр нийлүүлэх арга хэмжээ авах зохицуулалтыг тусгасан.
27	Эрдэс баялгийг боловсруулах	Иргэн Лхагвасүрэн	+				Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт,

	судалгааны үндэсний төв байгуулах талаар тусгах						өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд ийм төв байгуулж болохоор тусгагдсан учир энэ хуульд тусгах шаардлагагүй гэж үзсэн.
28	Түүхий эдийн эрэл хайгуулын асуудлыг тусгах	Иргэн Лхагвасүрэн	+				Ашигт малтмалын тухай хуульд энэ асуудал тодорхой тусгагдсан учир давхардуулах шаардлагагүй гэж үзсэн.
29	Хүнд үйлдвэрийн салбарт харъяалагдах жижиг, дунд үйлдвэрлэлийн асуудлыг маш тодорхой тусгах	Иргэн Лхагвасүрэн				+	Хуулийн төслийн 5.1, 5.2-д хүнд үйлдвэрийн ангиллыг тодорхой тусгасан.
30	Технологи дамжуулах талаар хуульд тусгах	Иргэн Лхагвасүрэн				+	Хуулийн төслийн 14.1.8-д технологи дамжуулах асуудлыг тодорхой тусгасан.
31	Хүнд үйлдвэрийн ангиллыг өөрчлөхгүй бол завсрын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хорголж, аргалж, ширэмийн үйлдвэрүүд зохицуулалтгүй байна.	Иргэн Лхагвасүрэн				+	Хуулийн төслийн 5.1-д ангиллыг тусгасан бөгөөд уг ангилалд багтах үйлдвэрлэлийн төрлийг 5.2-д заасны дагуу Засгийн газар батлахаар тусгасан.
32	Одоогийн байгаа үйлдвэрүүдээ түлхүү дэмжих чиглэлээр хуульд тусгах	Иргэн Лхагвасүрэн				+	Хуулийн төслийн 9, 10, 11 дүгээр зүйлд дэмжлэгийг тодорхой тусгасан.
33	Хөрөнгө оруулалт, зээл тусламжийн чиглэлээр хэрхэн дэмжиж ажиллах талаар тодорхой тусган	Иргэн Лхагвасүрэн				+	Хуулийн төслийн 14.1.2, 14.1.3 дахь заалтуудад тодорхой тусгасан.

	эзэнжүүлэх шаардлагатай.						
34	Хүнд үйлдвэрлэл нь өөрөө стратегийн ач холбогдолтой учраас төсөл шалгаруулах хэлбэрээр газар олгуулдаг байхаар хуулийн төсөлд тусгах	Иргэн Лхагвасүрэн	+				16.1.4.энэ хуулийн 5.1-д заасан хүнд үйлдвэрт газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр шийдвэрлэхээр заасан.
35	Гаднын ажиллах хүчний квотыг энэхүү хуульд тусгах	Иргэн Л.Бямбадорж	+				Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуулийн дагуу Аж ахуйн нэгж байгууллагад гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг тухайн байгууллагын нийт монгол ажиллагчдын тодорхой хувь хүртэл тухайн үед нь Засгийн газраас тогтоодог учир энэ заалтыг оруулах шаардлагагүй гэж үзсэн.
36	Хуулийн төслийн хүрээнд хамаарах жижиг, дунд үйлдвэрийг дэмжих дэмжлэгийг тодорхойлох	Жараахайн булаг ХХК захирал Г.Гэлэгжаргал				+	Хуулийн төслийн 9, 10, 15, 16 дугаар зүйлд Төрийн болон нутгийн захиргааны байгууллагаас үзүүлэх дэмжлэгийг тодорхой заасан. Түүнчлэн 14.1.3 дахь заалтад хамгаалалтын зохицуулалтыг тусгаж өгсөн.
37	Хүнд үйлдвэрийг татварын дэмжлэгт хамруулах заалт	Жараахайн булаг ХХК захирал Г.Гэлэгжаргал	+				Дагалдах хуулийн төсөлд Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлд

	оруулах, Гааль, НӨАТ гэх мэт						хуулийн төслийн 5.1-д заасан үйлдвэр барихад импортолсон техник, тоног төхөөрөмжийг барилга угсралтын ажлын хугацаанд гаалийн албан татвараас чөлөөлж, нэмэгдсэн өртгийн албан татварыг “0” хувь хэмжээгээр ногдуулах боломжтой байхаар тусгасан. Татварын ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэгт “Татварыг хөнгөлөх, чөлөөлөх, татварын хувь, хэмжээ болон татварын суурийг бууруулахтай холбогдсон хуулийн төслийг тухайн жилийн төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт боловсруулна” гэж заасны дагуу үйлдвэр барих зориулалтаар импортлох тоног төхөөрөмжийг татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах асуудлыг Сангийн яамтай тохиролцож 2022 оны төсөвт тусгах боломж бүрдэнэ.
38	Боловсон хүчнийг төрөөс бодлогоор бэлтгэдэг баймаар байна. Энэ чиглэлээр суралцаж буй	Жараахайн булаг ХХК захирал Г.Гэлэгжаргал	+				Хуулийн төслийн 11 дүгээр зүйлд Хүний нөөцийн хөгжлийн дэмжлэгийг тодорхой заасан.

	оюутнуудын сургалтын төлбөрийг хөнгөлөх, зээл олгох чиглэлээр дэмжих						
39	Дотоодын худалдан авалтыг хамгаалах, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах өгөх	Гэтженерос ХХК				+	Хуулийн төслийн 13.1.3 дахь заалтад тусгагдсан.
40	Хүнд үйлдвэрийн салбарын мэргэшсэн, зөвлөх инженерийн зэрэгтэй инженерүүдэд цалингийн нэмэгдэл, урамшуулал олгох тухай саналыг оруулах	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын инженер Арвис				+	Хуулийн төслийн 14.1.7.хүнд үйлдвэрийн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн эрх олгох асуудлыг их, дээд сургууль, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлахаар заасан. Энэ журамд тодорхой тусгагдана.

2.ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР ЭРДЭМТЭД, СУДЛААЧИД, ИХ ДЭЭД СУРГУУЛИЙН БАГШ НАРТАЙ ХИЙСЭН ОЛОН НИЙТИЙН ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН САНАЛ

№	Хуулийн төслийн холбогдох заалт	Байгууллага, хувь хүн	Ирүүлсэн санал				Тусгасан эсэх (Тайлбар, үндэслэл)
			Нэмэх	Хасах	Өөрчлөх	Найруулах	
1	5.1-д заасан Хар болон өнгөт төмөрлөгийн ангиллыг дараах байдлаар дэлгүүлж ангилах 5.2.2.1 Хар болон өнгөт металл боловсруулах	ШУТИС-ын МТС	+				Хуулийн төслийн 5.2-т энэ хуулийн 5.1-д заасан үйлдвэрлэлийн салбарт хамаарах ангиллын жагсаалтыг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын

	үйлдвэрт хэрэглэгдэх хагас боловсруулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэл (аргалж, хорголж, ангижруулсан төмөр), 5.2.2.2. Ган, ширэм хайлах үйлдвэр 5.2.2.3. Өнгөт метал хайлах үйлдвэр 5.2.2.4. Цутгуурын үйлдвэр 5.2.2.5. Даралтын боловсруулалтын үйлдвэр (цувих, шахах, сунгах) 5.2.2.6. Ферро хайлшийн үйлдвэр 5.2.2.7. Нунтаг металлургийн үйлдвэр 5.2.2.8. Хоёрдогч түүхий эдийг боловсруулах, зайлуулах; дахин ашиглах						ангилалтай уялдуулан Засгийн газар батлахаар тусгасан.
2	Гарааны бизнесийг эхлүүлэх, шинэ техник технологи нэвтрүүлэхэд шаардагдах хүний нөөцийг чадавхжуулахад болон мэргэжлийн ур чадварын тэмцээнийг зохион байгуулах үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх заалт тусгах	ШУТИС-ын МТС				+	Хуулийн төсөлд 12.1.2.салбарын хүний нөөцийн тасралтгүй хөгжлийг хангах тогтолцоог бүрдүүлэх; 12.1.3.хүний нөөцийг бэлтгэх, чадавхжуулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх; гэсэн заалтууд тусгагдсан.
3	Хуулийн төсөлд шинээр стандарт, норм дүрэм	ШУТИС-ын МТС	+				Хуулийн төслийн 10.2.3.хүнд үйлдвэрт

	боловсруулахад арга зүйн болон санхүүгийн дэмжлэг үзүүлэх, хэрэгжиж буй норм стандартуудыг олон улсын жишгийн дагуу шинэчлэхэд дэмжлэг үзүүлэх гэсэн заалт оруулах						нэвтрүүлэх, нутагшуулах үндэсний болон олон улсын стандартыг боловсруулах, батлуулахад дэмжлэг үзүүлэх заалт тусгагдсан.
4	Хүнд үйлдвэрийн тодорхойлолтыг зарим орнууд бүтээгдэхүүн үйлдвэрлэх нийлмэл олон шат дараалал, процессоос бүрдсэн их хэмжээний хөрөнгө оруулалт шаарддаг, олон тооны ажиллагсадтай үйлдвэрийг хэлнэ гэж тодорхойлсон байдаг. Иймд тодорхойлолтыг эргэн харах шаардлагатай гэж үзэж байна.	ШУТИС-ын ХШУС н.Илчгэрэл				+	Тодорхойлолтыг дахин нягталж “хүнд үйлдвэр” гэж эрдэс баялгийн гаралтай түүхий эд, материал, хаягдлыг боловсруулж бүтээгдэхүүн, эд анги, хөдөлмөрийн зэмсэг эсвэл дараагийн шатны үйлдвэрлэлийн материалд хувиргадаг шинжлэх ухаан, технологийн чадамж бүхий үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрийн салбаруудын нэгдлийг хэлнэ гэж тодорхойлсон.
5	Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх зорилгод “солонгоруулах” гэсэн үг орсон байна тэрийг “төрөлжүүлэх” гэж өөрчлөн найруулах саналтай байна.	ШУТИС-ын ХШУС н.Илчгэрэл				+	Хүнд үйлдвэрийг хөгжүүлэх зорилго нь эрдэс баялгийн боловсруулалтын түвшинг ахиулах, импортыг орлох, экспортод чиглэсэн нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх замаар үндэсний аюулгүй байдал,

							улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хангахад оршино.гэж тодорхойлсон.
6	Хуулийн төслийн 10.1.4 дээр хүнд үйлдвэр байгуулах газрыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр олгоно гэсэн байна. Мөн хуулийн төслийн 16.1.2 орон нутгийн эрх үүрэг дээр мөн адил заалт байна. Хүнд үйлдвэрийн төсөл нь тухайн хийгдсэн ТЭЗҮ-д үндэслэж байршлаа тодорхойлох ёстой байтал орон нутгийн төлөвлөгөөнд орсон газрыг сонгон авах юм шиг харагдаад байна.	ШУА-ийн доктор н.Шийрэв	+				Хуулийн төслийн 16.1.2-д энэ хуулийн 5.1-д заасан хүнд үйлдвэрт газрыг эзэмшүүлэх, ашиглуулах асуудлыг зөвхөн төсөл сонгон шалгаруулах хэлбэрээр шийдвэрлэхээр тодорхой заасан.
7	НҮБ-ээс гаргасан ангилалд нийцүүлэн гаргасан ЭЗҮАС-ын салбарын ангиллаар Хүнд үйлдвэрлэлийг ангилахаар жаахан хэцүү байна. Энэхүү ангиллыг харахаар жишээ нь металл боловсруулалт дээр үндсэн 4 ангилал байна. Энэхүү 4 нь дахиад задарч байна. Тиймээс ангиллын асуудлыг илүү тодорхой болгох хэрэгтэй байна.	ШУТИС-ийн МехТС-ийн багш н.Оюунбат	+			+	5.1.Хүнд үйлдвэрт дараах үйлдвэрлэлийн салбарыг хамруулна: 5.1.1.хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл; 5.1.2.машин үйлдвэрлэл; 5.1.3.металл боловсруулах үйлдвэрлэл; 5.1.4.нүүрс боловсруулах үйлдвэрлэл; 5.1.5.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл; 5.1.6.химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл;

	Бидний санал өгсөн ангилал маань ОХУ-д мөрдөгддөг ангилал байгаа юм. Жишээ нь өнгөт, хар металлурги боловсруулалт гэх мэт ангилал ЭЗҮАС-ын ангилалд байхгүй байна.						5.1.7.төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл; 5.1.8.төмөрлөгийн хог хаягдлыг боловсруулах үйлдвэрлэл. 5.2.Энэ хуулийн 5.1-д заасан үйлдвэрлэлийн салбарт хамаарах ангиллын жагсаалтыг эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилалтай уялдуулан Засгийн газар батална.гэж тодорхой тусгасан.
8	Ангиллын хувьд мэргэжлийн хүмүүсийн саналыг маш сайн авч тусгах шаардлагатай байна.	Эрдэнэт үйлдвэрийн ЗМЗ-ын дарга Баасансүрэн				+	Ангиллыг хуулийн төсөлд тодорхой тусгасан.
9	Энэ салбарт байгаа жижиг дунд үйлдвэрүүдийг дэмжих хөгжүүлэх шаардлага байгаа тул энэхүү хуулийн тусгах хэрэгтэй байна. Учир нь энэхүү үйлдвэрүүд дандаа хуулийн гадуур үлддэг.	Эрдэнэт үйлдвэрийн ЗМЗ-ын дарга Баасансүрэн				+	Хуулийн төслийн 9, 10, 11 дүгээр зүйлд дэмжлэгийн асуудлыг тусгасан.
10	Хүнд аж үйлдвэрийг хөгжүүлэх хууль цомхон, оновчтой байх шаардлагатай байна. Мега төслүүдийг дэмжих чиглэлээр энэхүү хуульд	Судлаач: С.Галсандорж				+	Хуулийн төслийн 14 дүгээр зүйлд энэ чиглэлээр холбогдох заалтууд тусгагдсан.

	түлхүү оруулж өгөх хэрэгтэй байна.						
11	Дэд бүтэц, түүхий эдэд тулгуурлаж мега төслүүдийг хэрэгжүүлэх тул энэхүү төслүүдийн ТЭЗҮ, зураг төслүүдийг холбогдох мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлэх, батлуулах гэж оруулж өгөх саналтай байна.	Судлаач: С.Галсандорж				+	Хуулийн төслийн 7, 14 дугаар зүйлд холбогдох заалтууд тусгагдсан.
12	Хүнд үйлдвэрийн тодорхойлолтыг оновчтой болгох хэрэгтэй байна. Энэхүү хуулийг гаргахдаа мега төслүүд дээр голчлон анхаарч, жижиг, дунд үйлдвэрлэлийг түр хойш нь тавих саналтай байна.	Судлаач: С.Галсандорж				+	Хуулийн төсөлд 4.1.5.“хүнд үйлдвэр” гэж эрдэс баялгийн гаралтай түүхий эд, материал, хаягдлыг боловсруулж бүтээгдэхүүн, эд анги, хөдөлмөрийн зэмсэг эсвэл дараагийн шатны үйлдвэрлэлийн материалд хувиргадаг шинжлэх ухаан, технологийн чадамж бүхий үйлдвэрлэл эрхэлж буй үйлдвэрийн салбаруудын нэгдлийг гэж тодорхойлсон.
13	Хуулийн төслийн 3.3.1 дээр хүнсний, жижиг, дунд үйлдвэр хамаарахгүй гэсэн байна. Энэ заалтаас жижиг, дунд гэдэг үгийг хасах саналтай байна. Учир нь манай үйлдвэр шиг хүнд үйлдвэр дундаа бага хүчин чадалтай	Шинжидай металл ХХК				+	Хуулийн төсөлд 4.1.5.“хүнд үйлдвэр” гэж эрдэс баялгийн гаралтай түүхий эд, материал, хаягдлыг боловсруулж бүтээгдэхүүн, эд анги, хөдөлмөрийн зэмсэг эсвэл дараагийн шатны үйлдвэрлэлийн материалд хувиргадаг шинжлэх ухаан,

	үйлдвэрүүд хаана хамаарах нь тодорхойгүй байна.						технологийн чадамж бүхий үйлдвэрлэл эрхэлж буй аж үйлдвэрийн салбаруудын нэгдлийг гэж тодорхойлсон нь төмөрлөгийн хаягдал боловсруулах үйлдвэрүүд хүнд үйлдвэрт хамаарна.
14	Үг, үсэг найруулгыг маш оновчтой тодорхойлж өгөхгүй бол болохгүй гэж бодож байна. Хуулийн төслийн 4.1.1 дэх заалт дээр "...тодорхой батлагдсан технологийн дагуу..." гэж өөрчлөн найруулах саналтай байна. Хуулийн төслийн 4.1.2 дахь заалтад "...тухай ажлын байранд мэргэжлийн хүний нөөц..." гэж оруулсан байна. Манай салбарт яг тухайн ажлын байранд мэргэжлийн хүний нөөц байхад хүндрэлтэй ихэвчлэн шинэ хүн дадлагажуулж, мэргэшүүлж авч байгаа. Тиймээс "тухай ажлын байранд мэргэжлийн баг хамт олон" гэж өөрчлөн найруулах саналтай байна. Хүнд үйлдвэрийн тухай тодорхойлолт дээр "...шинжлэх ухаан техник технологийн	Алтай хүдэр ХХК Доржсүрэн:				+	Үг, үсэг найруулгын шинжтэй засваруудыг хүлээн авч холбогдох заалтуудад найруулгын засвар хийсэн.

	багтаамжийг...” гэснийг “...шинжлэх ухаан техник технологийн чадамж...” гэж өөрчлөн найруулах саналтай байна. Хуулийн төслийн 6.1 дэх заалтад зорилтыг тодорхойлсон байна. Энэхүү зорилтод “...эдийн засгийг солонгоруулах...” гэснийг “...эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх...” гэж өөрчлөн найруулах саналтай байна. Хуулийн төслийн 17.1.3 дэх заалтад дэд бүтэц, усны асуудал орсон байна. Энэхүү заалтад хүрээнд гэж оруулах саналтай байна. Шаардлага гэж оруулахгүй, зөвлөмж гэж зөөлрүүлж хамтран ажиллах талаас нь оруулж өгөх саналтай байна.						
15	Хуулийн төслийг дэмжиж байна. Хүнд үйлдвэрийн хүний нөөцийн асуудал маш чухал байгаа тул хүний нөөцийг хэрхэн бэхжүүлэх талаар хуулийн төсөлд тусгах шаардлагатай байна. Юуны түрүүнд хүний нөөцийг бэлтгэхийн тулд жижиг туршилтын	ШУА-ийн доктор. н.Авид				+	Хуулийн төсөлд хүний нөөцийн хөгжлийн дэмжлэг гэсэн 12 дугаар зүйл , заалтууд тусгагдсан.

	үйлдвэр барих нь зүйтэй гэсэн зөвлөмжүүд өгсөн.						
16	Хүнд үйлдвэрт нүүрс боловсруулах үйлдвэр тэр дундаа баяжуулах үйлдвэр хамаарахгүй гэж үзэж байна уу?	ШУТИС-ын ХТС-ийн доктор н.Хандмаа				+	Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангиллын дагуу баяжуулах үйлдвэр хүнд үйлдвэрт хамаарахгүй байхаар тусгагдсан.
17	Коксын үйлдвэрлэл, газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл бас орхигдсон байна. Хуулийн төсөлтэй сүүлд танилцсан учир дахин сайн хараад өөрийн саналыг бичгээр өгье.	ШУТИС-ын ХТС-ийн доктор н.Хандмаа	+				Хуулийн төслийг 5.1.Хүнд үйлдвэрт дараах үйлдвэрлэлийн салбарыг хамруулна: 5.1.1.хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл; 5.1.2.машин үйлдвэрлэл; 5.1.3.металл боловсруулах үйлдвэрлэл; 5.1.4.нүүрс боловсруулах үйлдвэрлэл; 5.1.5.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл; 5.1.6.химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл; 5.1.7.төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл; 5.1.8.төмөрлөгийн хог хаягдлыг боловсруулах үйлдвэрлэл гэж тусгасан.
18	Хуулийн төслийг боловсруулсан баг хамт олонд баярлалаа. Ангилал дээр анхаарах шаардлагатай байна.	Судлаач н. Ариунжаргал				+	Хуулийн төслийг 5.1.Хүнд үйлдвэрт дараах үйлдвэрлэлийн салбарыг хамруулна: 5.1.1.хар болон өнгөт төмөрлөгийн үйлдвэрлэл;

							5.1.2.машин үйлдвэрлэл; 5.1.3.металл боловсруулах үйлдвэрлэл; 5.1.4.нүүрс боловсруулах үйлдвэрлэл; 5.1.5.газрын тосны бүтээгдэхүүний үйлдвэрлэл; 5.1.6.химийн бодис, химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл; 5.1.7.төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн эдлэл үйлдвэрлэл; 5.1.8.төмөрлөгийн хог хаягдлыг боловсруулах үйлдвэрлэл гэж тусгасан.
19	Энэхүү хууль нь мега төсөлд зориулах уу, жижиг дунд үйлдвэрлэлд зориулах уу гэдгийг тодорхой болгох хэрэгтэй байна.	Судлаач н. Ариунжаргал				+	Аль алинд нь хамаарахаар зохицуулалт хийсэн.
20	Манай улсад төмөрлөг, гангийн чиглэлийн мэргэжлийн боловсон хүчин байхгүй байна. Иймд урт, дунд, богино хугацааны мэргэжилтэн бэлтгэх чиглэлээр бодлогын түвшинд дэмжиж хуульд тусгаж өгөөч гэж хүсэж байна.	Судлаач н.Ундармаа				+	Хуулийн төслийн 12 дугаар зүйлд хүний нөөцийн дэмжлэгийн талаар тодорхой тусгасан.
21	Салбарын мэргэшсэн, зөвлөх инженерүүдийн цалин урамшуулал, нэмэгдлийн асуудлыг	Судлаач н.Ундармаа	+				Хуулийн төслийн 14.1.8.хүнд үйлдвэрийн салбарын мэргэшсэн мэргэжилтэн, шинжээчийн

	хуульд тусгаж өгөөч гэж хүсэж байна.						эрх олгох асуудлыг их, дээд сургууль, мэргэжлийн төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх журмыг батлахаар заасан. Энэ журамд тодорхой тусгагдана.
--	--------------------------------------	--	--	--	--	--	---

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН БОДЛОГЫН ГАЗАР